

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2021 оны 01 дүгээр сарын 27 ны өдөр
Тендер шалгаруулалтын нэр: **ТУ-тай шугам хоолой** нийлүүлэх

Тендер шалгаруулалтын дугаар: **ДЦС-4/2021-86**

“ДЦС-4” ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос **ТУ-тай шугам хоолой** нийлүүлэх цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө 50.000 /Тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн борлуулалтын жил бүрийн борлуулалт нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна. /2018,2019 он /
2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.
3. Аудитаар баталгаажуулсан санхүүгийн **зөрчилгүй дүгнэлттэй тайлан** ирүүлэх жилийн тоо: сүүлийн 2 жил. 2018, 2019 он
4. Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй /2018, 2019 он/ Ашигтай ажилласан жилийн тоо -2 жил
5. Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл шаардлагатай эсэх: *“тийм” Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл,тендерт санал болгож буй материалыг үйлдвэрлэдэг үйлдвэрийн танилцуулга ,технологи нийлүүлэх талаар / Монгол хэл дээр / ирүүлэх ,Ийм төрлийн өндөр даралтын шугам хоолой нийлүүлж байсан туршлагатай байх*
- 6.Тендерийн хамт төсөвт өртөгийн 2%-буюу 12,716,087.26 /арван хоёр сая долоон зуун арван зуогаан мянга наян долоон төгрөг хорин зургаан мөнгөний тендерийн баталгаа ирүүлнэ.

Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгааг хүлээн зөвшөөрнө.

Хүчинтэй байх хугацаа: 2021 оны 04 дугаар сарын 18 ний өдөр дуустал

Тендерийг 2021 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 10.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2021 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.


Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж, “ДЦС-4” ТӨХК-ийн Захиргааны байр, 3 дугаар давхар, 310 тоот өрөө Худалдан авах ажиллагааны хэлтэс Утас 7018-1309, 7000-1357, 7017-1357, Факс 7018-1309 7000-1357

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ХААХ-Н ДАРГА



У.ТӨМӨРХУЯГ

В.ЛХАГВАДОРЖ